

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
8-Р АНГИЙН МАТЕМАТИК ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа 70 минут


А ХУВИЛБАР

Нийт оноо 40

Сурагчийн нэр Анги

СОНГОХ ДААЛГАВАР: /Бодлого бүр 1 оноотой./

- 64.39 гэсэн тоог 3 тэмдэгтийн тоогоор тоймлоорой.
A.64.5 B. 64.4 C. 64 D. 64.39
- $4a^3b^2 \times 3a^2b =$ утгыг олоорой.
A. $12a^3b^3$ B. $12a^5b$ C. $12a^5b^3$ D. $12a^4b^3$
- 9, 16, 23, 30, ... арифметик прогрессийн 10-р гишүүнийг ол.
A.72 B.54 C.80 D.67
- $\frac{(a-3)^2}{a^2-9} =$
A. $\frac{a-3}{a+3}$ B. $\frac{a+3}{a-3}$ C. $\frac{a-9}{a+3}$ D. $\frac{3-a}{9}$
- Мэдэгдэхгүй байгаа өнцгийг олоорой.



- A. 55° B. 70° C. 100° D. 60°


- Мэдэгдэхгүй байгаа өнцгийн хэмжээг олоорой.



- A. 70° B. 20° C. 140° D. 55°

- Хоёр шоог зэрэг хаях туршилтад нийт хэдэн эгэл үзэгдэл илрэх вэ?
A. 6 B.12 C.36 D.24
- Токарчин 3 цаг, түүний туслах 4 цаг ажиллаад 153 деталь хийв. Хэрэв тэд 1 цагт нийлээд 45 деталь хийдэг бол 108 деталийг туслах хэдэн цагт хийх вэ?
A. 6 B. 2.4 C. 4 D.3.
- $\left(\frac{1}{b-c} - \frac{1}{b+c}\right) \frac{2b+2c}{c} =$ үйлдлийг гүйцэтгээрэй.
A. $\frac{4}{b-c}$ B. $\frac{b+c}{2}$ C. $\frac{c}{b+c}$ D. $\frac{2}{c+b}$
- $(5x + 1)^2 =$ олон гишүүнт хэлбэрт бичээрэй.
A. $25x^2 + 5x + 1$ B. $25x^2 + 10x + 1$
C. $5x^2 + 10x + 2$ D. $25x^2 + 24x + 1$
- $y=9x+7$ тэгшитгэлийн шийд болох хос тоог олоорой.
A. (1,16) B.(2, 15) C.(1, 12) D.(3, 36)


12. $(5;0)$ ба $(1; -3)$ хоёр цэгийн хоорондох зайг олоорой.
 A. 5 B. 4 C. 6 D. 8
13. 5 цагаан, 3 улаан бөмбөгнөөс санамсаргүй 1 бөмбөг авчээ. Тэр бөмбөг цагаан байх магадлалыг олоорой.
 A. $\frac{5}{8}$ B. $\frac{3}{8}$ C. $\frac{1}{6}$ D. $\frac{3}{5}$
14. 7,8,8,12,13,15,19 түүврийн далайцыг олоорой.
 A. 11 B. 9 C. 5 D. 12
15. $\begin{cases} 4x + 3y = 6 \\ 2x + y = 4 \end{cases}$
 A. $(3;-2)$ B. $(-2;3)$ C. $(4;3)$ D. $(2;5)$
16. 320000 төгрөгийн хөлдөөгчийг хямдруулаад 224000 төгрөгөөр авчээ. Хөлдөөгч хэдэн хувь хямдарсан бэ?
 A. 70% B. 65% C. 30% D. 20%
17. Доорх шулууны налалтыг олоорой.



- A. 3 B. -2 C. $\frac{1}{2}$ D. 2

18. Адил хажуут гурвалжны хүрээний урт 20 см. Хажуу тал нь 8 см бол суурийн уртыг олоорой.
 A. 5 B. 8 C. 6 D. 4
19. ABCD тэгш өнцөгтийн талууд нь 12:5 харьцаатай бөгөөд түүний диагональ 26 см бол тэгш өнцөгтийн бага талын уртыг ол.
 A. 24см B. 20 см C. 16 см D. 10 см
20. Диаграмм дээр ажиллаарай.

90 хүнээс авсан судалгааны дүнг гистограммаар харуулжээ. $[6, 9[$ завсар дахь баганын өндрийг ол.



- A. 12 B. 15 C. 10 D. 8

ЗАДГАЙ ДААЛГАВАР

- $3(x + 2) - 4 > 2x + 8$ тэнцэтгэл бишийг бод.
- Тойргийн урт 20см бол радиус болон диаметрийг олоорой.
- Хоёр оронтой тоо таамгаар сонгоход бичиглэлд нь 5-ийн цифр оролцсон байх магадлалыг ол.
- 40%-ийн 1200г давсны уусмал байв. Давсны концентрацийг 75% болгохын тулд ямар хэмжээний ус ширгээх хэрэгтэй вэ?
- Цилиндрийн суурийн радиус 10 м, эзлэхүүн нь 1520см.куб бол цилиндрийн өндөр болон гадаргуугийн талбайг олоорой.

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
8-Р АНГИЙН МАТЕМАТИК ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа 70 минут


Б ХУВИЛБАР

Нийт оноо 40

Сурагчийн нэр Анги


СОНГОХ ДААЛГАВАР: /Бодлого бүр 1 оноотой./

- 12.64 гэсэн тоог 3 тэмдэгтийн тоогоор тоймлоорой.
A.12.6 B. 13.0 C. 12.63 D. 12.7
- $5a^3b^2 \times 3a^2b =$ утгыг олоорой.
A. $15a^3b^3$ B. $15a^5b$ C. $15a^5b^3$ D. $15a^4b^3$
- 2, 4, 6, 8, ... арифметик прогрессийн 10-р гишүүнийг ол.
A.1 B.20 C.12 D.14
- $\frac{3x-y}{9x^2-y^2}$ бутархайг хураа.
A. $\frac{1}{3x+y}$ B. $\frac{3}{3x-y}$ C. $\frac{2y}{3x+y}$ D. $\frac{3}{3x+y}$
- Мэдэгдэхгүй байгаа өнцгийг олоорой.



- A. 75^0 B. 25^0 C. 22.5^0 D. 15^0

- Мэдэгдэхгүй байгаа өнцгийн хэмжээг олоорой.



- A. 60^0 B. 40^0 C. 30^0 D. 120^0

- Хоёр шагайг зэрэг хаях туршилтад нийт хэдэн эгэл үзэгдэл илрэх вэ?
A. 20 B.16 C.36 D.32
- Оёдолчин 4 цаг түүний туслах 5 цаг ажиллаад 264 алчуур оёв. Хэрэв тэд 1 цагт нийлээд 60 алчуур оёдог бол 180 алчуурыг туслах нь хэдэн цагт оёх вэ?
A. 4.4 B. 5 C. 7.5 D. 3
- $\left(\frac{x}{x-y} - \frac{x}{x+y}\right) : \frac{xy}{x+y} =$ үйлдлийг гүйцэтгээрэй.
A.1 B. $-\frac{2}{y}$ C. $\frac{2}{x+y}$ D. $\frac{2}{x-y}$
- $(4x + 5)^2 =$ олон гишүүнт хэлбэрт бичээрэй.
A. $16x^2 + 20x + 25$ B. $16x^2 + 40x + 25$
C. $16x^2 - 20x + 25$ D. $16x^2 + 10x + 25$
- $y = 5x - 1$ тэгшитгэлийн шийд болох хос тоог олоорой.
A. (1,3) B.(2, 8) C.(0, 1) D.(0, -1)

12. (1; -1) ба (-4; 11) хоёр цэгийн хоорондох зайг олоорой.

- A. 15 B. 14 C. 13 D. 8

13. 6 цагаан, 8 улаан бөмбөгнөөс санамсаргүй 1 бөмбөг авчээ. Тэр бөмбөг улаан байх магадлалыг олоорой.

- A. $\frac{5}{14}$ B. $\frac{4}{7}$ C. $\frac{3}{7}$ D. $\frac{3}{14}$

14. 7, 8, 8, 12, 13, 14, 15, 20 түүврийн далайцыг олоорой.

- A. 8 B. 15 C. 13 D. 11


15. $\begin{cases} 2x + 5y = 25 \\ 4x + 3y = 15 \end{cases}$ систем тэгшитгэлийн шийдийг ол.

- A. (5; 0) B. (5; 3) C. (0; 5) D. (3; 1)

16. Баярын хямдарлаар хивс 24% хямдраад 364800 төгрөгийн үнэтэй болсон бол анх ямар үнэтэй байсан бэ?

- A. 348600 B. 416800 C. 324400 D. 480000

17. Доорх шулууны налалтыг олоорой.



- A. 3 B. -2 C. $\frac{1}{2}$ D. 2


18. Тэгш өнцөгтийн талууд 2: 3 ба диагональ нь $\sqrt{52}$ см бол талуудыг ол.

- A. 8см, 6см B. 4см, 6см C. 10см, 15см D. 2см, 3см

19. Адил хажуут гурвалжны хүрээний урт 30см, хажуу нь 12см бол суурийн уртыг олоорой.

- A. 9 B. 8 C. 6 D. 10

20. 50 хүнээс авсан судалгааны дүнг гистограммаар харуулав. [3, 5[завсар дахь баганын өндрийг олоорой.



- A. 4 B. 5 C. 6 D. 7

ЗАДГАЙ ДААЛГАВАР

- $2(2x - 3) + 3x \leq 10x - 5$ тэнцэтгэл бишийг бод.
- Тойргийн урт 30см бол радиус болон диаметрийг олоорой.
- Хоёр оронтой тоо таамгаар сонгоход бичиглэлд нь 3-ийн цифр оролцсон байх магадлалыг ол.
- 18%-ийн алтны агууламжтай 40кг зэс-алтны хайлш байв. Алтны агууламжийг 15% болгохын тулд хэдэн килограмм зэс холих хэрэгтэй вэ?
- Цилиндрийн суурийн радиус 12 см, өндөр нь 20 см бол эзлэхүүн, гадаргуугийн талбайг олоорой.